



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

678. Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2481

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

679. Монгол Улсын Их Хурлын зарим гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Дугаар 63 2482

680. Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Дугаар 64 2483

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

681. Цэргийн анги, байгууллагыг нэгтгэн, өөрчлөн зохион байгуулах тухай Дугаар 122 2483

682. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 123 2485

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

683. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын зарим хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 05 2487

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 12 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хүний хөгжил сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:**

“3.4.Сангийн тухайн жилийн төсвийн алдагдлыг Засгийн газрын бонд, өрийн бичиг, зээл, үнэт цаас гарган санхүүжүүлж, үндсэн болон хүүгийн төлбөрийг сангаас төлж болно.”

**2/17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалт:**

“17.1.5.хүүхдийн мөнгө.”

**3/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:**

“17.3.Хүний хөгжил сангийн тухайн жилийн төсвийн тухай хуулиар хүүхдийн мөнгөнд тесөвлөгдсөн хөрөнгөөс зарцуулагдаагүй үлдэгдлийг зөвхөн хүүхдийн хөгжлийг дэмжих зориулалтаар дараа жилийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тусган зарцуулна.”

**2 дугаар зүйл.**Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Иргэн” гэсний дараа “энэ хуулийн 17.1.5-д зааснаас бусад” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “энэ хуулийн 3.2,” гэсний дараа “3.4.” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “энэ хуулийн” гэсний дараа “3.4.” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.4 дэх хэсгийн дугаарыг “17.4, 17.5” болгон өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 12 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Их Хурлын зарим гишүүний  
бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай**

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.2



дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Дашжамцын Арвин, Гаваагийн Батхүү, Даваажанцангийн Сарангэрэл нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 12 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

**Засгийн газрын үнэт цаас  
гаргахыг зөвшөөрөх тухай**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүний хөгжил сангийн төсвийн алдагдал, тус сангийн төсвийн цаг зуурын хүндрэлийг даван туулахад зориулан 313.1 тэрбум /гурван зуун арван гурван тэрбум нэг зуун сая/ төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг 2012 оны төсвийн жилд гаргаж, арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуягт/-т зөвшөөрсүгэй.

2.Энэхүү тогтоолыг 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 11 дүгээр  
сарын 3-ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар  
хот

**Цэргийн анги, байгууллагыг нэгтгэн,  
өөрчлөн зохион байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-ыг үндэслэн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний дагуу үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын бие бүрэлдэхүүнд үйлчлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтад оруулах зорилгоор Хууль зүйн яамны харьяа “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг”, Батлан хамгаалах яамны харьяа “Зэвсэгт хүчний клиникийн төв госпиталь”-ыг нэгтгэн “Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг” болгон өөрчлөн зохион байгуулж, Батлан хамгаалах яамны харьяанд ажиллуулсугай.

2. Цэргийн анги, байгууллагыг өөрчлөн зохион байгуулсантай холбогдуулан Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эзэмшиж, ашиглаж байгаа барилга байгууламжаас бусад эд хөрөнгийг балансаас балансад орон тоо, төсвийн хамт Батлан хамгаалахын сайдын төсвийн багцад шилжүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Сангийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай.

3. Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг байгуулсантай холбогдуулан эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, үйлчлэх хүрээ, ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Батлан хамгаалахын сайд Д.Бат-Эрдэнэ, Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Эрүүл мэндийн сайд Н.Удвал нарт үүрэг болгосугай.

4. Шинэчлэлийн Засгийн газрын бодлого, хууль зүйн үйлчилгээг чанаржуулах, нийтэд хүртээмжтэй болгох зорилтын хурээнд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн зориулалтаар барьж байгаа барилгыг Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүйн яамны албан контор, иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх төвийн зориулалтаар өөрчлөн засаж, тус тус балансад нь шилжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Хууль зүйн сайд Х.Тэмүүжин, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг байгуулах тухай” Засгийн газрын 2000 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ

Х.ТЭМҮҮЖИН



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 11 дүгээр  
сарын 10-ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар  
хот

### Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 10.6, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ийн 2.1-д дараах агуулга бүхий заалт нэмсүгэй:

“архи согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь;

-эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өргтийн албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгө.”

3. Мөн дүрмийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулга бүхий 4.1.9-4.1.13 дахь заалт нэмсүгэй:

“4.1.9. нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх;

4.1.10. нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлын талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;

4.1.11. эмнэлгийн мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн захиалгаар зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

4.1.12. анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих;

4.1.13. эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах.”

4. Мөн дүрмийн 4.1.1 дэх заалтын “эрүүл мэндийг дэмжих” гэсний өмнө “Тамхи, архины болон эмийн зохисгүй хэрэглээнд тавих хяналтыг

сайжруулах” гэж, 4.1.5 дахь заалтын “архины” гэсний дараа “болон эмийн зохисгүй” гэж, 4.1.7 дахь заалтын “урьдчилан сэргийлэх” гэсний дараа “эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” гэж, 3.1, 5.3 дахь заалт болон мөн Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөлийн ажиллах журам”-ын 2.2 дахь заалтын “захиргааны” гэсний дараа “төв” гэж, мөн журмын 3.1.1 дэх заалтын “төрийн захиргааны төв байгууллагад” гэсний дараа “хуулиар тогтоосон төсвийн цаглабарын хугацаанд” гэж тус тус нэмсүгэй.

5. Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн зөвлөлийн ажиллах журам”-ын 1.1 дэх заалтын “9” гэснийг “11” гэж, 3.1.7 дахь заалтын “мэргэжил” гэснийг “удирдлага,” гэж тус тус өөрчилсүгэй.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 366 дугаар тогтоол, Засгийн газрын 2007 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм”-ийн 4.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

**Н.УДВАЛ**

Засгийн газрын 2012 оны 123 дугаар  
тогтоолын хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДХҮҮН**

- |                     |  |
|---------------------|--|
| <b>Дарга</b>        | -Эрүүл мэндийн сайд  |
| <b>Орлогч дарга</b> | -Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга   |
| <b>Гишүүд:</b>      | <ul style="list-style-type: none"><li>-Татварын ерөнхий газрын дарга;</li><li>-Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга;</li><li>-Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;</li><li>-Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;</li></ul> |



- Соёл, спорт, аялал жуулчлалын яамны  
Биесийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг  
зохицуулах газрын дарга;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын  
Хэрэглэгчийн эрхийн газрын дарга;
- Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн  
Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн захирал;
- Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн  
ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын нийгмийн эрүүл мэндийн  
мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх  
захирал (тохиролцсоноор).

**Нарийн бичгийн  
дарга**

- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл  
мэндийн хэлтсийн дарга.

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

2012 оны 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн  
1 дүгээр хавсралтын зарим хэсэг Үндсэн хуулийн  
холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, гишүүдэд Т.Лхагваа, Д.Наранчимэг /илтгэг/, Д.Сугар, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Зол-Үндрах оролцов. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Баярцогт, Б.Болор нар хүрэлцэн ирээгүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтын XII.3.1.19,

XII.3.1.26, XII.3.1.27, XII.3.1.29 дэх хэсгүүд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Зол-Ундрах Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:**

“Монгол Улсын Их хурлаас 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын зарим хэсэг, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна гэж үзэн дараах мэдээллийг гаргаж байна. Үүнд:

Монгол Улсын 2012 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XII.3.1.19-д “Жи-Мобайлын дэд станц байгуулах /Төв, Заамар/, XII.3.1.26-д “Аймгийн бүх багийн төвүүдийг Жи-Мобайл сүлжээгээр холбоожуулах, интернэтэд холбох /Ховд/, XII.3.1.27-д “Хөдөөгийн алслагдсан сум, багийн иргэд, малчдыг үүрэн холбооны Жи-Мобайл сүлжээний өргөтгөлөөр бүрэн холбоожуулах, интернэтжүүлэх хөтөлбөр /Хөвсгөл, 24 сум, 125 баг/, XII.3.1.29-д Хөдөөгийн алслагдсан сум, багийн иргэд, малчдыг үүрэн холбооны Жи-Мобайл сүлжээний өргөтгөлөөр бүрэн холбоожуулах, интернэтжүүлэх хөтөлбөр /Архангай Хотонт, Орхон баг, Тариат, Мөрөн, Цагааннуур, Алтайд багууд, Жаргалант, Хоолт, Асуйт багууд, Булган, Тусгайл баг, Эрдэнэмандал, Идэр-Улаан баг, Цахир, Хан-Уул баг, Чулуут, Халуун-ус баг, Цэцэрлэг, Туулант баг, Цэнхэр, Цэцэрлэг баг, Их тамир, Хөхнуур баг, Хангай, Тэрх баг, Өндөр-Улаан, Хануй баг, Батцэнгэл, Улаанчулуу баг/” гэж тус тус заасан байгаа нь Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтуудыг зөрчсөн байна гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан байdag ба харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд ялгавартай хандан төсвийн орлогыг “Жи Мобайл” ХХК-д тусгайлан оноож хуульчлан баталсан байгаа нь Улсын Их Хурал нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, 6.4.6-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх” гэсэн



заалтыг зөрчөөд зогсохгүй Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн явдал боллоо.

Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасан байdag ба “Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хууль”, түүний 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын “Жи Мобайл”-тай холбоотой зарим хэсэг Үндсэн хуультай зөрчилдэж байна.

Монголын ард түмэн бид Үндсэн хуулийнхаа эрхэм зорилгод шударга ёс, төрт ёсыг хүндэтгэн үзэж эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилгоо болгож, үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо тунхагласан байгаа билээ. Гэтэл Улсын Их Хурлаас баталсан байгаа хууль нь Үндсэн хуулийн дээр дурдсан Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг шууд зөрчсөнөс гадна Үндсэн хуулийн эрхэм зорилтыг үл хайхран Үндсэн хуульт ардчилсан Монгол улс биш, хэн нэгэн, хэсэг бүлгийн ашиг сонирхол Монголын ард түмний эрх ашгийн өмнө тавигддаг луйврын шинжтэй болсон нь харагдаж байна.

Монгол Улсын 2012 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XII.3.1.19, XII.3.1.26, XII.3.1.27, XII.3.1.29 дахь хэсгүүдийг хүчингүй болгох, гэсэн мэдээллийг ирүүлжээ.

**Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:**

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хууль”, түүний 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-ын “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн заалт, Далдугаар зүйлийн 1-ийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тухай мэдээллийг иргэн Б.Зол-Үндрэх гаргажээ...

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд нэгдсэн чуулган болон холбогдох байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, уг төсвийг баталсан.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “Улсын Их Хурал нь улсын төсвийн орлого, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээний санхүүжилт, бусад санхүүжилтийг хэлэлцэж батална” гэж, 7.1.4-т Засгийн газар улсын төсвийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээний санхүүжилтийг тодорхойлох гэж тус тус заасан. Мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч бүр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, түүнд шаардлагатай санхүүжилтийг улсын төсвөөс хуваарилан авдаг, түүнчлэн улсын төсвийн хөрөнгөөр аливаа бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлах ёстай. Гэтэл Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад хэд хэдэн төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлэхээр тодорхой нэг компанийг тусгайлан заасан нь дээр дурдсан хуулийн заалтуудтай зөрчилдөхөөр байна.

Иймд иргэн Б.Зол-Үндрахын мэдээллийг хүлээн авах үндэслэлтэй гэж үзэж байна.” гэжээ.

*Гурав. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх явцад Цэцийн гишүүн миний бие Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягт хандан тайлбар гаргуулахаар албан бичиг явуулсан бөгөөд, уг албан бичгийн хариуд Монгол Улсын Сангийн сайдас 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр 3-4/5566 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна. Уз тайлбар:*

“... Сангийн яамнаас Засгийн газарт өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төсөлд дээрх төсөл, хөтөлбөрийг тусгаагүй байсан боловч төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төслийг Засгийн газар дээр хэлэлцэж байх үед XII.3.1.19-д “Жи Мобайлын дэд станц байгуулах /Төв, Заамар/ төслийг нэмж тусгасан ба төсвийн төслийг хэлэлцүүлэх шатанд Архангай, Ховд, Хөвсгөл, аймгуудын зарим сум,



багийг Жи-Мобайл үүрэн холбооны сүлжээнд холбох дээр дурдсан бусад төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган баталсан байна...” гэжээ.

### ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын 2012 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XII.3.1.19-д “Жи-Мобайлын дэд станц байгуулах /Төв, Заамар/, XII.3.1.26-д “Аймгийн бүх багийн төвүүдийг “Жи-Мобайл” сүлжээгээр холбоожуулах, интернэтэд холбох /Ховд/, XII.3.1.27-д “Хөдөөгийн алслагдсан сум, багийн иргэд, малчдыг үүрэн холбооны “Жи-Мобайл” сүлжээний өргөтгөлөөр бүрэн холбоожуулах, интернэтжүүлэх хөтөлбөр /Хөвсгөл, 24 сум, 125 баг/, XII.3.1.29-д “Хөдөөгийн алслагдсан сум, багийн иргэд, малчдыг үүрэн холбооны “Жи-Мобайл” сүлжээний өргөтгөлөөр бүрэн холбоожуулах, интернэтжүүлэх хөтөлбөр /Архангай Хотонт, Орхон баг, Тариат, Мөрөн, Цагааннуур, Алтайд багууд, Жаргалант, Хоолт, Асуйт багууд, Булган, Тусгайл баг, Эрдэнэмандал, Идэр-Улаан баг, Цахир, Хан-Уул баг, Чулуут, Халуун-ус баг, Цэцэрлэг, Туулант баг, Цэнхэр, Цэцэрлэг баг, Их тамир, Хөхнуур баг, Хангай, Тэрх баг, Өндөр-Улаан, Хануй баг, Батцэнгэл, Улаанчулуу баг/” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дерөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1/ дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын 2012 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XII.3.1.27-д “Хөдөөгийн алслагдсан сум, багийн иргэд, малчдыг үүрэн холбооны “Жи-Мобайл” сүлжээний өргөтгөлөөр бүрэн холбоожуулах, интернэтжүүлэххөтөлбөр/Хөвсгөл, 24 сум, 125 баг/, XII.3.1.29-д “Хөдөөгийн алслагдсан сум, багийн иргэд, малчдыг үүрэн холбооны “Жи-Мобайл” сүлжээний өргөтгөлөөр бүрэн холбоожуулах, интернэтжүүлэх хөтөлбөр /Архангай Хотонт, Орхон баг, Тариат, Мөрөн, Цагааннуур, Алтайд багууд, Жаргалант, Хоолт, Асуйт багууд, Булган, Тусгайл баг, Эрдэнэмандал, Идэр-Улаан баг, Цахир, Хан-Уул баг, Чулуут, Халуун-ус баг, Цэцэрлэг, Туулант баг, Цэнхэр, Цэцэрлэг баг, Их тамир, Хөхнуур баг, Хангай, Тэрх баг,



Өндөр-Улаан, Хануй баг, Батцэнгэл, Улаанчуулуу баг/” гэсэн хэсэг 2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хавсралт “Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тодотгосон жагсаалт”-ын Х.3.1.18, Х.3.1.20-д хэвээр батлагдсан байх бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчөөгүй байна.

2.Монгол Улсын 2012 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын XII.3.1.19-д “Жи-Мобайлын дэд станц байгуулах /Төв, Заамар/, XII.3.1.26-д “Аймгийн бүх багийн төвүүдийг “Жи-Мобайл” сүлжээгээр холбоожуулах, интернэтэд холбох /Ховд/” гэсэн хэсэг 2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тодотгосон жагсаалт”-аас хасагдсан байх тул дээрх хэсгүүд Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалт зөрчсөн тухай мэдээлэл гаргагчийн мэдээллийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.

3.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Н.ЖАНЦАН**

**ГИШҮҮД**

**Т.ЛХАГВАА  
Д.НАРАНЧИМЭГ  
Д.СУГАР  
Д.МӨНХГЭРЭЛ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_meddeel@parliament.mn

**Утас:** 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс:** 14003